

АРИГ ГАЛ ХК-ийн УДИРДЛАГАД

Утга: АРИГ ГАЛ ХК-ийн удирдлагад санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, дотоод хяналтын системийн сул талуудад өгөх зөвлөмж

ХҮНДЭТ Х.ХАНИЯ ТАНАА

Бид АРИГ ГАЛ ХК-ийн 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлогууд, бусад тайлбар тодруулгуудад аудит хийсэн юм. Аудитын үйл ажиллагааг Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн.

Аудитын явцад дараах горимуудыг баримтлан ажилласан.

- Санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлт, дотоод хяналтын системийг судлах, шаардлагатай үед холбогдох ажилтнаас асуулга авах
- Санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлт, дотоод хяналтын үйл ажиллагааг тодорхойлох, эрсдэлийг үнэлэх
- Шаардлагатай санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлт, дотоод хяналтын үйл ажиллагааг тестлэх
- Дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар үнэлгээ хийх

Тус байгууллагын санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлт, дотоод хяналтын талаарх горим нь санхүүгийн тайлангийн аудитыг хэрэгжүүлэх явцад зайлшгүй хийгдэх горимууд бөгөөд энэ нь байгууллагын санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлт, дотоод хяналтын системийн үр дүнтэй байгаа эсэх талаар дүгнэлт өгөх зорилгыг агуулаагүй, харин нөхцөл байдалдаа тохирсон аудитын горимуудыг тодорхойлоход чиглэгдсэн.

Удирдлагад хүргүүлж байгаа энэхүү захидал нь аудитыг хэрэгжүүлэх явцад бидний анхааралд өртсөн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлт, дотоод хяналтын системд оршин байгаа сул талууд, тэдгээрийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг удирдлагын анхааралд хандуулах, аудиторын зүгээс өгөх зөвлөмжийг танилцуулах зорилготой юм. Захидалд дурдсан зүйлс нь аудитын явцад бидний анхааралд өртсөн зүйлс бөгөөд оршин байгаа бүх сул талыг агуулсан тайлан гэж ойлгож болохгүй юм.

1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагналын талаар

Бодит байдал:

1. Халаасны хувьцааг нягтлан бодох бүртгэлд бүртгэх, санхүүгийн тайланд бүртгэх асуудлаар компани дотроо бүртгэх зарчмыг тодорхойлсон нэгдсэн журам, заавар, аргачлалгүй байсан ба халаасны хувьцааг балансын актив дансанд буруу бүртгэсэн байна.

Зөвлөмж:

Халаасны хувьцааны “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-т тусгах шаардлагатай ба хувьцаа халааслах бүртгээ аргачлал тодорхойгүй улмаас янз бүрийн аргаар бүртгэх магадлалтай байна. Бид аудитын шалгалтын явцад эздийн өмчид бүртгэгдсэн хувьцаа, болон халаасны хувьцааны бүртгэлд 2015 оноос хойш баталгаажуулалт хийсэн. Компани нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 3,479,320 ширхэг энгийн хувьцаанаас бүрддэг. Хувьцааг нэрлэсэн үнээр бүртгэсэн. Тайлант хугацаанд компани 12560 ширхэг хувьцаа халаасалсан ба үүнд нийт 36,399,890 төгрөгийг зарцуулсан. 2015 оноос хувьцаа халааслахдаа нэрлэсэн үнийн аргаар бүртгэсэн тул 35,143,890.17 төгрөгийг тайлант хугацаанд нэмж төлөгдсөн капитал дансанд бүртгэсэн залруулгыг хийлээ. Компанийн хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр гаргасан хувьцаагаа эргүүлэн худалдан авсныг халаасны хувьцаа гэнэ.

- Компани өөрийн үнэт цаасыг эргүүлэн худалдан авах нөхцөл:

- а. Үнэт цаасыг эргүүлэн худалдан авмагц шууд төлбөрийн чадвартай байх
- б. Компанийн сүүлийн баланст тусгагдсан өөрийн хөрөнгийн хэмжээ нь компанийн дүрэмд заасан хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийн хэмжээ болон давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгах үеийн үнэ зэргийн нийлбэрээс их байх

1. Компани хувьцаагаа эргүүлэн худалдаж авснаар өөрийн хөрөнгө нь энэ хэлцлийг хийхийн өмнөх сүүлийн балансад тусгасан хэмжээнээс 25-аас дээш хувиар багассан тохиолдолд төлбөр хийсэн өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор зээлдүүлэгчид өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ.

2. Компани хувьцаагаа эргүүлэн худалдаж авах шийдвэрийг гаргахдаа дараах зүйлсийг харгалзан үзэх хэрэгтэй .

- а. Энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджийн 25%-с хэтрэхгүй байх;
- б. Энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь буюу зарим хэсгийг худалдан авч болно.
- в. ТУЗ үнэт цаас худалдан авах шийдвэртээ худалдан авах хувьцааны тоо, үнэ, төлбөр хийх хугацаа, ашиглах журам зэргийг зааж өгнө.
- д. Компани өөрийн компанийн үнэт цаасыг анхдагч зах зээлд гаргах үед худалдан авахыг хориглоно.
- е. Хувьцаагаа эргүүлэн худалдаж авснаар өөрийн хөрөнгө нь тухайн үеийн балансад тусгагдсан хувь нийлүүлсэн хөрөнгөнөөс багассан

тохиолдолд хувьцааг эргүүлэн худалдан авахыг хориглоно.

3. Компани өөрийн гаргасан энгийн хувьцааны 5-с дээш хувийг худалдан авах шийдвэрийг дор дурдсанаас бусад тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Энгийн хувьцаа худалдан авахдаа хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн авахаар шийдвэрлэсэн бол

- a. Хувьцаа эзэмшигчдийн давуу эрхийг хэрэгжүүлж байгаа бол
- b. Компанийн дүрмээр өөр нөхцөл тогтоосон бол

Халаасны хувьцааг дараах 2 аргаар бүртгэлд тусгана.

- a. Өртгийн арга: Халаасны хувьцаа дансыг худалдан авсан өртгөөр нь Дт-лэж, дахин гаргах үед худалдаж авсан өртгөөр Кт-лэнэ. Энэ аргын үед халаасны хувьцаа дансыг балансад эздийн өмчийн доор хасагдах байдлаар тусгадаг.
- b. Нэрлэсэн үнийн арга: Халаасны хувьцаа дансыг нэрлэсэн үнээр нь Дт-лэх бөгөөд хувьцааны анхны гаргалтын дүнг одоогийн худалдан авсан өртөгтэй нь харьцуулж үзнэ. Анхны гаргалтын дүнгээс бага үнээр худалдан авсан тохиолдолд зөрүүг нь халаасны хувьцааны НТК дансны Кт-д, харин илүү үнээр худалдан авсан тохиолдолд халаасны хувьцаа дансыг нэрлэсэн үнээр Дт-лэж, зөрүүг халаасны хувьцааны нэмж төлөгдсөн капитал данс Кт үлдэгдэлтэй бол тэр дүнгээр уг дансыг бууруулж үлдэх дутагдлын дүнгээр хуримтлагдсан ашиг дансыг бууруулна. Энэ аргын үед халаасны хувьцаа дансыг балансад энгийн хувьцааны доор хасагдах байдлаар тусгадаг.

4. Халаасны хувьцааг эргэлтээс гаргах тохиолдолд энгийн болон халаасны хувьцаа дансыг нэгэн зэрэг бууруулна.

Үйлчлүүлэгчийн хариу:

2022 оны аудитын дүгнэлтийн дагуу санхүүгийн тайлангаа залруулах болно.

Аудитын өгсөн зөвлөмжийн дагуу цаашид анхаарч ажиллах болно.

Удирдлагын захидлыг монгол хэл дээр 2 эх хувь бэлтгэсэн ба хуулбарт утгын зөрүү гарвал эх хувийг баримтална. Бидний өгч буй зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ гэдэгт итгэж байна. Та бүхний ажилд амжилт хүсье.